

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Галт сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/41/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

Мөрөн сум

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Ахлах аудитор: Д.Алтайбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ДЗОУБ	Дэлхийн зөн олон улсын байгууллагаас
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/183
танай -ны № -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЛТ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
П.НАРАНЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Галт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Галт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	53,569,709.01	128,115,188.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	2,204,881.62
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	2,204,881.62
3121	Төгрөг	00.00	2,204,881.62
31211	Төрийн сангийн харилцах	00.00	2,204,881.62
33	АВЛАГА	150,000.00	42,811,500.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	42,661,500.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	150,000.00	150,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	53,419,709.01	83,098,806.90
351	Түүхий эд материал	17,396,316.64	44,231,131.93
35110	Тусгай зориулалттай материал	8,769,885.00	7,834,638.00
35130	Эм боох материал	8,626,431.64	36,396,493.93
354	Хангамжийн материал	36,023,392.37	38,867,674.97
35410	Бичиг хэргийн материал	1,485,500.00	1,848,220.00
35420	Аж ахуйн материал	29,006,597.61	31,328,047.61
35440	Түлш, шатах тослох материал	4,680,014.20	1,960,008.00
35460	Хүнсний материал	851,280.56	3,731,399.36
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,058,564,813.54	1,038,478,305.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,058,564,813.54	1,038,478,305.57
392	Биет хөрөнгө	1,030,552,813.54	1,021,716,305.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	993,932,839.43	988,629,914.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	-47,060,235.57	-73,100,848.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,013,792.00	67,013,792.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-40,053,007.50	-51,804,889.37
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	117,607,436.00	155,102,094.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-78,973,661.42	-80,470,146.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,321,775.00	31,416,475.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,884,278.80	-15,625,034.33
39214	Бусад үндсэн хөрөнгө	808,382.20	808,382.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-202,027.80	-295,234.20
39217	Ном	41,800.00	41,800.00
393	Биет бус хөрөнгө	28,012,000.00	16,762,000.00
39301	Програм хангамж	15,550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,300,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,762,000.00	16,762,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,112,134,522.55	1,166,593,494.09
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,208,756.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,208,756.00
413	Өглөг	00.00	3,208,756.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	3,208,756.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,112,134,522.55	1,163,384,738.09
51	Засгийн газрын хувь оролцоо	1,112,134,522.55	1,163,384,738.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	378,942,809.45	378,942,809.45
51101	Өмч: - төрийн	378,942,809.45	378,942,809.45
512	Хуримтлагдсан үр дүн	300,714,757.27	357,601,897.81
51210	Өмнөх үеийн үр дүн	300,714,757.27	306,351,682.27
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	51,250,215.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	432,476,955.83	426,840,030.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,112,134,522.55	1,166,593,494.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,199,608,369.23	1,354,741,065.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,094,253,299.23	1,033,034,865.93
120	Нийтлэг татварын бус орлого	520,841,299.23	436,052,865.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	520,841,299.23	436,052,865.93
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	520,841,299.23	436,052,865.93
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	573,412,000.00	596,982,000.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	573,412,000.00	596,982,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	105,355,070.00	321,706,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,560,000.00	210,445,590.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	124,400.00	119,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,435,600.00	49,559,490.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000,000.00	1,627,500.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	159,139,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,241,700.00	60,813,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,241,700.00	60,813,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	55,553,370.00	50,447,510.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	55,553,370.00	50,447,510.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	775,240,396.55	1,289,019,750.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	775,240,396.55	1,289,019,750.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	763,562,939.54	1,242,583,974.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	456,782,843.00	520,967,475.00
210101	Үндсэн цалин	295,037,238.00	318,400,773.00
210102	Нэмэгдэл	130,795,971.00	160,534,677.00
210104	Урамшуулал	30,949,634.00	30,881,428.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	11,150,597.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,899,903.00	68,735,923.34
210201	Тэтгэврийн даатгал	39,473,259.00	49,207,223.34
210202	Тэтгэмжийн даатгал	4,625,561.00	4,882,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,680,287.00	3,905,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	920,073.00	976,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,200,723.00	9,764,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,271,893.19	55,311,330.10
210301	Гэрэл, цахилгаан	2,885,931.39	3,537,973.90
210302	Түлш, халаалт	47,385,961.80	50,666,956.20
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,106,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,211,739.65	39,665,441.00
210401	Бичиг хэрэг	1,977,300.00	4,249,780.00
210402	Тээвэр, шатахуун	20,569,679.65	26,589,161.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,900,000.00	3,087,000.00
210404	Ном, хэвлэл	64,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	666,400.00	1,450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,824,200.00	4,289,500.00

210408	Бараа материал акалсны зардал	1,210,160.00	00.00
2105	Нормативт зардал	101,089,549.24	492,469,278.66
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,017,949.24	478,062,537.46
210502	Хоол, хүнс	9,071,600.00	14,406,741.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,800,000.00	6,986,000.00
210604	Урсгал засвар	2,800,000.00	6,986,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,804,000.00	1,207,000.00
210702	Дотоод албан томилолт	1,804,000.00	1,207,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,381,768.00	1,487,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,555,808.00	242,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,950.00	188,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,010.00	87,010.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,321,243.46	55,753,566.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,750,000.00	2,824,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	92,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,571,243.46	52,837,166.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,677,457.01	46,435,776.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	45,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	45,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.61	1,235,776.10
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.61	1,235,776.10
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,677,456.40	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,677,456.40	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	424,367,972.68	65,721,315.54
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	14,471,100.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	14,471,100.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-14,471,100.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	424,367,972.68	51,250,215.54

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,942,809.45	-123,653,215.41	687,766,549.87
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	378,942,809.45	-123,653,215.41	687,766,549.87
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	424,367,972.68	424,367,972.68
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,942,809.45	300,714,757.27	1,112,134,522.55

D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,942,809.45	300,714,757.27	1,112,134,522.55
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	5,636,925.00	5,636,925.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	378,942,809.45	306,351,682.27	1,117,771,447.55
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	-5,636,925.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	51,250,215.54	51,250,215.54
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,942,809.45	357,601,897.81	1,163,384,738.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	678,617,070.00	876,026,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	573,412,000.00	596,982,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	573,412,000.00	596,982,000.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	573,412,000.00	596,982,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	105,205,070.00	279,044,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,410,000.00	167,784,090.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	124,400.00	119,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,285,600.00	49,559,490.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,000,000.00	1,627,500.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	116,478,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,241,700.00	60,813,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,241,700.00	60,813,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	55,553,370.00	50,447,510.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	55,553,370.00	50,447,510.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	678,617,070.00	870,708,818.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	678,617,070.00	870,708,818.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	666,939,612.99	824,273,042.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	456,782,840.00	517,758,719.00
210101	Үндсэн цалин	295,037,235.00	315,192,017.00
210102	Нэмэгдэл	130,795,971.00	160,534,677.00
210104	Урамшуулал	30,949,634.00	30,881,428.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	11,150,597.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,899,906.00	68,735,923.34
210201	Тэтгэврийн даатгал	39,473,260.00	49,207,223.34
210202	Тэтгэмжийн даатгал	4,625,561.00	4,882,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,680,288.00	3,905,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	920,074.00	976,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,200,723.00	9,764,400.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,013,099.39	52,591,323.90
210301	Гэрэл, цахилгаан	2,885,931.39	3,537,973.90
210302	Түлш, халаалт	46,127,168.00	47,946,950.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,106,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,739,000.00	41,209,711.00
210401	Бичиг хэрэг	1,833,600.00	3,897,600.00
210402	Тээвэр, шатахуун	19,903,000.00	26,589,161.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,900,000.00	3,087,000.00
210404	Ном, хэвлэл	64,000.00	165,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	666,400.00	2,439,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,372,000.00	5,031,950.00
2105	Норматив зардал	54,768,999.60	129,245,105.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,598,999.60	111,424,705.04
210502	Хоол, хүнс	6,170,000.00	15,820,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,800,000.00	7,986,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	2,800,000.00	6,986,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,804,000.00	1,207,000.00
210702	Дотоод албан томилолт	1,804,000.00	1,207,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,381,768.00	2,037,860.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,555,808.00	242,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,950.00	188,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,010.00	87,010.00
210805	Тээврийн хэрэгслийн оншлогоо	40,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	549,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,750,000.00	3,501,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,750,000.00	2,824,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	677,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,677,457.01	46,435,776.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	45,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	45,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.61	1,235,776.10
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.61	1,235,776.10
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,677,456.40	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,677,456.40	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	5,317,881.62
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	3,113,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	3,113,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	3,113,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	3,113,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-3,113,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	2,204,881.62

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,204,881.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	713,015,500.0	704,801,952.3	8,213,547.7	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	713,015,500.0	704,801,952.3	8,213,547.7	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	713,015,500.0	704,801,952.3	8,213,547.7	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	488,215,900.0	487,422,564.0	793,336.0	99.8
210101	Үндсэн цалин	315,647,200.0	315,192,017.0	455,183.0	99.9
210102	Нэмэгдэл	130,249,100.0	130,198,522.0	50,578.0	100.0
210104	Урамшуулал	31,160,000.0	30,881,428.0	278,572.0	99.1
210105	Гэрээт ажлын хөлс	11,159,600.0	11,150,597.0	9,003.0	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,909,200.0	64,967,009.3	942,190.7	98.6
210201	Тэтгэврийн даатгал	46,380,500.0	45,438,309.3	942,190.7	98.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,882,100.0	4,882,100.0	00.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,905,800.0	3,905,800.0	00.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	976,400.0	976,400.0	00.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	9,764,400.0	9,764,400.0	00.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,813,100.0	52,591,323.9	1,221,776.1	97.7
210301	Гэрэл, цахилгаан	4,200,000.0	3,537,973.9	662,026.1	84.2
210302	Түлш, халаалт	48,000,000.0	47,946,950.0	53,050.0	99.9
210303	Цэвэр, бохир ус	1,613,100.0	1,106,400.0	506,700.0	68.6
2104	Хангамж, бараа материалын зардал	34,080,000.0	33,957,121.0	122,879.0	99.6
210401	Бичиг хэрэг	3,500,000.0	3,500,000.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	21,237,000.0	21,213,671.0	23,329.0	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,050,000.0	3,047,000.0	3,000.0	99.9
210404	Ном, хэвлэл	293,000.0	165,000.0	128,000.0	56.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.0	1,999,500.0	500.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.0	4,031,950.0	-31,950.0	100.8
2105	Нормативт зардал	50,680,500.0	50,567,674.0	112,826.0	99.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,510,500.0	40,404,874.0	105,626.0	99.7
210502	Хоол, хүнс	8,170,000.0	8,162,800.0	7,200.0	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,800,000.0	11,800,000.0	00.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,800,000.0	1,345,000.0	2,455,000.0	35.4

Галт сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.0	1,000,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	7,000,000.0	6,986,000.0	14,000.0	99.8
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.0	523,000.0	977,000.0	34.9
210702	Дотоод албан томилолт	1,500,000.0	523,000.0	977,000.0	34.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,016,800.0	5,936,400.0	1,080,400.0	84.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	242,000.0	242,000.0	00.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.0	850,000.0	00.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.0	188,950.0	11,050.0	94.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.0	87,010.0	12,990.0	87.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.0	20,000.0	20,000.0	50.0
210807	Газрын төлбөр	100,000.0	100,000.0	00.0	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.0	5,499,000.0	4,499,000.0	549.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,484,800.0	3,404,400.0	1,080,400.0	75.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,484,800.0	3,404,400.0	1,080,400.0	75.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	713,015,500.0	707,006,833.9	6,008,666.1	99.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	596,982,000.0	596,982,000.0	00.0	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	596,982,000.0	596,982,000.0	00.0	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	60,813,100.0	59,577,323.9	1,235,776.1	98.0
132001	Орон нутгийн төсвөөс	60,813,100.0	59,577,323.9	1,235,776.1	98.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	55,220,400.0	50,447,510.0	4,772,890.0	91.4
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	55,220,400.0	50,447,510.0	4,772,890.0	91.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,204,881.62	2,204,881.6	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,020.00	58,301.00	-57,281.0	-
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00	-7,323.0	-
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00	-4,090.0	998.9
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00	-45,868.0	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	167,784,090.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	167,784,090.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	122,584,090.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,336,155.00

210102	Нэмэгдэл	30,336,155.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,768,914.00
210201	Тэтгэврийн даатгал	3,768,914.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,440,590.00
210401	Бичиг хэрэг	397,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,375,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,627,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00
2105	Норматив зардал	78,677,431.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,019,831.00
210502	Хоол, хүнс	7,657,600.00
2107	Томилолт, зочны зардал	684,000.00
210702	Дотоод албан томилолт	684,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	677,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	677,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	45,200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	167,784,090.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	167,784,090.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	119,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,559,490.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,627,500.00
131106	Төсвийн урамшуулал	116,478,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий Аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Галт сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, Нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн Анхан шатны баримт бүрдүүлэлт, Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, Давтан гаргасан зөрчилтэй холбоотой асуудалд зөвлөмж, албан шаардлага өгч тус тус тусгасан болно.

Аудитыг Ахлах аудитор Д.Алтайбаяр, аудитор О.Оюунцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Галт сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Галт сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, ил тод хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан, ард иргэдэд эрүүл зөв амьдрах дадал үйлийг оновчтой тэгш хүртээмжтэйгээр хүргэж, орон нутгийн иргэдийн дундаж наслалт, амьдралын чадамжийг уртасгах, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулж ажиллах зорилго тавьсан байна.

Хөвсгөл аймгийн Галт сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх
- Сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, Санхүү, Нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх оноосон нэрийг өөрчлөх тухай.
- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны 04 сарын 30-ны 67/А/268 дугаар тушаалаар Ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай
- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны А/387/99 журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай
- “Хөвсгөл аймгийн засаг даргын захирамж” 2021 оны А243 түр журам батлах тухай. Ковид-19-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх түр журмаар баталсан байна.
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох Хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галт сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 704.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Галт сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 54.5 сая төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, дансны өглөг, хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдлийг харуулав.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.0	2.2	2.2
Авлага	00.2	42.8	42.7
Бараа материал	53.4	83.1	29.7
Биет хөрөнгө	1,030.6	1,021.7	-08.8
Биет бус хөрөнгө	28.0	16.8	-11.3
Нийт хөрөнгө	1,112.1	1,166.6	54.5
Дансны өглөг	00.0	03.2	03.2
Хуримтлагдсан үр дүн	300.7	357.6	56.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,112.1	1,166.6	54.5

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2.2 сая төгрөг болж өссөн байна. Төрийн сангийн хэлтсээс татан төвлөрүүлэлгүй харилцах дансанд үлдээсэн байна. Энэ нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19-ын цар тахал Монгол Улсад эрчимтэй тарсантай холбоотойгоор Эрүүл мэндийн төвүүдийг гүйцэтгэлийн санхүүжилтээр явагдаж байгаа тул тухайн байгууллагын дансны үлдэгдлийг 2021 онд Сангийн яамд төврүүлээгүйтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 42.6 сая төгрөг байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас ковид цар тахлын үед иргэдэд үзүүлсэн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтийн авлага 42.6 сая төгрөг байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 29.7 сая төгрөгөөр өсөж 83.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материал 182.2 сая төгрөг,
- Галт сумын ЗДТГ-аас олгосон 10.9 сая төгрөг,
- Оном сангаас олгосон 0.6 сая төгрөг,
- Эрүүл мэндийн газраас эрх шилжүүлэн авсан вакцин, эм тариа 378.9 сая төгрөг,
- Санхүүгийн хяналт, аудитын албаны тооллогоор илүү гарсан орлого 0.6 сая төгрөг,
- ДЗОУБ-аас олгосон 0.8 сая төгрөг,
- Тайлант хугацаанд хугацаа дууссан эм, эм боох материал 0.56 сая төгрөгийн материал акталж, 543.9 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Биет хөрөнгийн үлдэгдэл 8.8 сая төгрөгөөр буурч 1,021.7 сая төгрөг болсон байна. Материаллаг нөлөөтэй биет хөрөнгө:

- Улсын төсвийн хөрөнгөөр 3.1 сая төгрөгийн биет хөрөнгө худалдан авч,
- Иргэний хандиваар авсан хүчилтөрөгчийн аппарат угаалгын машин принтер нийт 5.7 сая төгрөг,
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 07-ны өдрийн А/49 тоот тушаалаар “МонПэн” төслийн хүрээнд тавилга, хэрэгсэл, компьютер техник хэрэгсэл 4.9 сая төгрөг,
- Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 07 сарын 27-ны өдрийн А/91 тушаалаар хог хаягдлын автоклав 9.7 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 11 сарын 15-ны өдрийн А/116 тушаалаар шээсний анализатор, лабораторийн генетологийн аппарат нийт 14.2 сая төгрөг,
- Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 07 сарын 27-ны өдрийн А/90 тушаалаар 3.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж,
- Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 12 сарын 17-ны өдрийн А/148 тушаалаар 5.5 сая төгрөгийн дархлаажуулалтын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж,
- Акталж данснаас хассан биет хөрөнгө 28.9 сая төгрөг, дахин үнэлгээ хийж орлогод авсан 23.5 сая төгрөг,
- Биет хөрөнгийн элэгдэл 52.8 сая төгрөг,

Нийт 28.9 сая төгрөгийн биет хөрөнгө данснаас хасагдсан.

Тайлант хугацаанд Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 12 сарын 30-ний өдрийн 118-р тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 27.5 сая төгрөгийн биет хөрөнгө данснаас хассан, Хөвсгөл аймгийн Галт сумын иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн 2021 оны 12 сарын 30-ны өдрийн 35-р тогтоолоор 1.4 сая төгрөг акталсан.

Биет бус хөрөнгө нь 11.3 сая төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын 111 дугаар тогтоолоор “Цахим эрүүл мэнд” программыг акталсантай холбоотой байна. “Цахим эрүүл мэнд” программ хангамжийг 2012 онд авч түүнээс хойш ашиглаагүй, гэхдээ өмнөх онд байгуулсан 3.7 сая төгрөгийг элэгдлийг хасаж данснаас хассантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 713.0 сая төгрөгөөр, зарлагыг мөн үнийн дүнгээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсөв захирагч 2021 оны төсвийн төслийг 713.0 сая төгрөгөөр баталсан, төсвийн тодотгол хийгээгүй байна. Үүнд:

- Улсын төсвөөс 596.9 сая төгрөг,
- Орон нутгийн төсвөөс 60.8 сая төгрөг,
- Эрүүл мэндийн даатгалын сангаас 55.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Эмнэлгийн тусламж үйлчилгээ” хөтөлбөрийн хүрээнд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 487.4 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 64.9 сая төгрөг, байр ашиглалттай

холбоотой тогтмол зардал 52.6 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 34.0 сая төгрөг, норматив зардал 50.5 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардал 9.3 сая төгрөг, томилолтын зардалд 0.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 2.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 3.4 сая төгрөг нийт 704.8 сая төгрөгийн гүйцэтгэл гарч үүнээс 4.7 сая төгрөг дутуу санхүүжилт авч, 1.3 сая төгрөгийн буцаан төвлөрүүлэлт хийсний дээр оны эцэст 2.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Материаллаг нөлөөтэй санхүүжилтийг харуулбал:

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд ЭМГ-ын даргын 2021 оны 10 сарын 1-ний өдийн А/ 114 тоот тушаалаар 12.6 сая төгрөг, мөн газрын даргын 2021 оны 8 сарын 4-ны өдрийн А/92 тоот тушаалаар 32.6 сая төгрөг, ЭМГ-ын даргын 2021 оны 4 сарын 15-ны өдрийн А/ 40 тоот тушаалаар 0.2 сая төгрөг, А/41 тоот тушаалаар 0.7 сая төгрөг, нийт 49.6 сая төгрөгийг дээд шатны эрх захирагчаас, орон нутгийн өмчид бус байгууллагаас авсан хандив тусламж 0.1 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.6 сая төгрөг, ЭМД-ын сангаас ковидын цогц тусламж үйлчилгээний зориулалттай 116.5 сая төгрөг, нийт 167.8 сая төгрөгийг хуваарилсан байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 30.3 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 3.8 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 8.4 сая төгрөг, норматив зардалд 78.7 сая төгрөг, дотоод албан томилолтод 0.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 0.7 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 45.2 сая төгрөг, нийт 167.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийт 210.4 сая төгрөгийн санхүүжилт авахаас 167.8 сая төгрөгийн санхүүжилт авч үлдэгдэл 42.7 сая төгрөгийн авлагатай, тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал, үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.
- Ковидын тархалттай холбогдсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ихээхэн нэмэгдсэн. Ковидоор 242 хүн өвчилж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, дархлаажуулалтаар 7456 тун вакцинд иргэдийг хамруулж нийт 160.2 сая төгрөг нэхэмжилснээс 117.6 сая төгрөгийн санхүүжилт авч 42.7 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал:

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.
- 2021 оны төсвийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Төрийн сангийн хэлтсээс татан төвлөрүүлэлгүй харилцах дансанд үлдээж баталгаажуулсан байна.

Энэ байгууллагын Төрийн сангийн үндсэн дансанд 2.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн Аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Галт сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 840.0 сая төгрөгийн 86 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 2 мэдээлэл,
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн 2 мэдээлэл,
- Төсвийн хэтрэлт хэмнэлтийн 1 мэдээлэл байна,

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумдын хүн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өөрчилсөн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайланг Ихэр мөрөн аудит ХХК аудит хийж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн биет ба биет бус хөрөнгийг акталж данснаас хасах, дахин үнэлэх тухай 2 зөвлөмж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж, нийт 3 зөвлөмж өгснөөс биет хөрөнгийг данснаас хасах 1 зөвлөмж хэрэгжиж, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 271 дүгээр тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчил илэрлээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитын цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллах нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад нийт 54.0 сая төгрөгийн 3 алдаа илрүүлж, 11.4 сая төгрөгийн 1 залруулж, 1 албан шаардлага, 42.6 сая төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд эм, эмнэлгийн хэрэгслийг 11.4 сая төгрөгөөр давхардуулан бүртгэсэн Нягтлан бодох бүртгэлийн алдааг аудитын хугацаанд залруулсан болно.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

1. Давтан гаргасан зөрчилтэй холбоотой асуудал

Өмнөх оны аудитын зөвлөмжөөс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 271 дүгээр тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй 2 зөрчил илэрснээс шилэн данстай холбоотой асуудал дахин давтагдан 5 мэдээлэл хугацаа хоцроосонд шаардлага өгөв. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 271 дүгээр тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд нь бүрэн ил тод мэдээлэх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Татварын ерөнхий хуулийн 28.5 заалтын дагуу эм боох материалын нийт худалдан авалт 116.7 сая төгрөгийн худалдан авалтыг түүвэрт бүрэн хамруулж И-баримт-тай тулган шалгахад 42.6 сая төгрөгийн худалдан авалтад И-баримт шивүүлээгүй зөрчил илэрлээ.

2.1. Өгсөн зөвлөмж:

Татварын ерөнхий хуулийн 28.5 заалт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх" -ыг хэрэгжүүлж ажиллах. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумдын хүн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өөрчилж тус тушаалаар дараах тушаалууд хүчингүй болсон байна. Үүнд: Эрүүл мэндийн сайдын Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2003 оны 114, Сумдын эмнэлгийн статусыг өөрчлөх тухай 2011 оны 292, Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2013 оны 256 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосон байна. Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх оноосон нэрийг өөрчлөөгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Улсын бүртгэлийн гэрчилгээнд оноосон нэрийг өөрчлөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Галт сумын эрүүл мэндийн төв	4	54.0	1	11.4	-	-	1	-	2	42.6

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.